

Монголбанк, Дэлхийн банкны хамтарсан сургалт, семинар

Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба Дэлхийн банктай хамтран 2010 оны 9 дүгээр сарын 21, 22, 23-ны өдрүүдэд банк, санхүүгийн байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хэрхэн хяналт шалгалт хийх талаар Монголбанкны Хяналт шалгалтын газар, Санхүүгийн зохицуулах хорооны Бичил санхүүгийн газар, Үнэт цаасны газар болон Даатгалын газрын хянан шалгагч нарт сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар зайнаас тавих хяналт, газар дээрх хяналт шалгалтын арга хэлбэр, баримтлах зарчим, шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэсэн арга хэмжээ авахад анхаарах зүйлсийн талаар зааж, олон улсын туршлагаас танилцууллаа.